

ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

N	Үзүүлэлтүүд	Хуучин стандарт	Шинэчилж буй стандарт
1	Стандартын нэр /Монголоор/	Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар. MNS 6356:2012	Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар. MNS 6356:2023
2	Стандартын нэр /Англиар/	The information, communication, postal mobile office	The information, communication, postal mobile office
3	Хэрэгцээ шаардлага	.	<p>Монгол Улсын аж ахуйн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ өргөнөөр нэвтэрч улс орноо “Цахим Үндэстэн” болох зорилтын хүрээнд өнөөдөр мөрдөгдөж буй стандартыг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд уялдуулах, мэдээлэл харилцаа холбооны салбарт тус стандартыг мөрдөж буй үйлчилгээний компаниудыг стандарт мөрдөх талаар үнэн зөв мэдээллээр хангах зэрэг шаардлага урган гарсан.</p> <p>1) Өнөөдөр МШХХ-ны үйлчилгээг алслагдсан бүс нутагт бүх нийтийн үүрэг хүлээсэн цөөн тооны үйлчлэгч хүргэж байгаа.</p> <p>2) Үүнтэй зэрэгцэн e- Монгол төрийн нэгдсэн платформ бүхий үйлчилгээг хөдөө орон нутагт нэвтрүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>Энэхүү стандартууд шинэчлэгдсэнээр:</p> <p>a) Цахим шилжилтийн талаар хүн амыг анхан шатны мэдлэг , мэдээллээр хангах</p> <p>b) цаашид шилжилт бүрэн хийгдсэний Монгол улсын алслагдсан нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдэд хүргэх МШХХ болон төрийн, бизнесийн бусад анхан шатны цогц үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</p>

			<p>с) хөдөө орон нутагт шинэ ажлын байр нэмэгдүүлэх</p> <p>d) үйлчилгээ эрхлэгчийн ашиг орлого нэмэгдэх зэрэг өргөн боломж бүрдэнэ.</p> <p>Түүнчлэн салбарын хэмжээнд төдийгүй бусад аж ахуйн салбарууд энэ үйлчилгээнд нэгдэн орсноор хэрэглэгчийн амьдралын чанар сайжрах юм.</p>
	Зорилго		<p>Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг Монгол улсын алслагдсан аймаг, сум, баг, дүүрэг, хороо, багт “Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар”/цаашид хөдөлгөөнт салбар гэх/-аар хүргэхэд тавигдах ерөнхий шаардлагыг тогтоох зорилгоор энэхүү стандартыг боловсруулсан болно.</p>
	Хамрах хүрээ	<p>Энэ стандартаар Монгол Улсын алслагдсан аймгууд, дүүрэг, хороо, сум, багуудын хүн ам, байгууллагуудад мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, электрон худалдаа болон банк, санхүүгийн үйлчилгээг хүргэж, үйлчилгээний хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зориулалттай ашиглах мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарт тавих ерөнхий шаардлагыг тогтоосон.</p>	<p>Стандарт нь Монгол улсын нутаг дэвсгэрт мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын үйлчилгээ эрхлэгч хувь хүн, хуулийн этгээд, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөнө</p>
4	Стандартаар тодорхойлсон үзүүлэлт, шаардлагууд	<p>a) Хамрах хүрээ</p> <p>b) Нэр томьёо, тодорхойлолт</p> <p>c) Ерөнхий шаардлага</p> <p>d) Шуудангийн үйлчилгээний хэсэг</p> <p>e) Интернет үйлчилгээний хэсэг</p> <p>f) Харилцаа холбооны үйлчилгээний хэсэг</p> <p>g) Банк, санхүүгийн үйлчилгээний хэсэг</p> <p>h)</p>	<p>a)Зорилго</p> <p>b)Хамрах хүрээ</p> <p>c) Нэр томьёо, тодорхойлолт</p> <p>e) Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын үйлчилгээ</p> <p>f) Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын зориулалтын автомашин, ажлын байр</p> <p>g) Үйлчилгээний ажилтанд тавигдах шаардлага</p> <p>h) Үйлчилгээний ажилтны харилцааны ур чадварт тавигдах шаардлага</p>

5	Норматив эшлэл	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 2. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 <p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа MNS 4930:2000 2. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, ангилал MNS 4931:2000 3. Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага MNS ISO 13688:2000 <p>Шуудангийн ажлын байр MNS 5540:2005</p> <p>Мэдээлэл, харилцаа холбооны ажилтны ажлын байранд тавигдах стандарт MNS:2008</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 2. Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 <p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа MNS 4930:2000 2. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, ангилал MNS 4931:2000 3. Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага MNS ISO 13688:2000 <p>Шуудангийн ажлын байр MNS 5540:2005</p> <p>Мэдээлэл, харилцаа холбооны ажилтны ажлын байранд тавигдах стандарт MNS:2008</p> <p>Дэлхийн Шуудангийн Байгууллага (UPU)-ын веб хуудас болон дараах эх сурвалжийг ашиглаж судалж, эшлэл авсан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. https://tools.usps.com/find-location.htm?location=1373428 2. https://www.postoffice.co.uk/branch-finder/7142307/over-mobile-service 3. https://postandparcel.info/61336/news/post-office-ltd-rolls-out-40-mobile-post-offices-for-rural-areas/
6	Нэр томьёо, тодорхойлолт	<p>2.1 мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар/цаашид хөдөлгөөнт салбар гэнэ/ хот, аймгийн алслагдсан дүүрэг, хороо,</p>	<p>3.1 “Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар” гэж тээврийн хэрэгсэл ашиглан алслагдсан хороо, багийн хүн амд хуулиар тогтоосон</p>

	<p>сум, багуудын хүн ам, байгууллагуудад батлагдсан хуваарийн дагуу мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, электрон худалдаа болон банк, санхүүгийн үйлчилгээг хүргэх зорилгоор тусгайлан тоноглогдсон бага оврын авто тээврийн хэрэгсэл;</p> <p>2.2 мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын ажилтан мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, электрон худалдаа болон банк, санхүүгийн үйлчилгээг үйлчлүүлэгчдэд борлуулах, заавар зөвлөгөө өгөх, сургалт хийх үндсэн үүрэг бүхий мэдээлэл, шуудан, харилцаа холбооны чиглэлээр мэргэшсэн жолооч – ажилтан;</p> <p>2.3 үйлчлүүлэгчдэд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан техник хэрэгслээр тусгайлан тоноглогдсон бага оврын авто тээврийн хэрэгслийн бүхээгийн хэсэг;</p> <p>2.4. хөдөлгөөнт салбарт зориулагдсан бага оврын авто тээврийн хэрэгсэл MNS 4598:2011, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан автомашин;</p> <p>2.5. батлагдсан хуваарь “Шуудангийн тухай хууль”-ийн 10.2-т заасан эрх бүхий этгээдийн баталсан хуваарь, чиглэл;</p> <p>2.6. электрон худалдаа интернэт болон мэдээллийн бусад сүлжээгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах үйл ажиллагаа.</p>	<p>хяналтын хугацаанд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээг хүргэх хөдөлгөөнт цэг;</p> <p>3.3 “Үйлчилгээний ажилтан” гэж мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, борлуулах, заавар зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий мэдээлэл, шуудан, харилцаа холбооны мэргэшсэн ажилтан</p> <p>3.2 “Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын тээврийн хэрэгсэл” гэж тусгай зориулалтын механик болон цахим техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон ажил гүйцэтгэхэд шаардлагад нийцсэн, аюулгүй байдлыг хангасан авто машин;</p> <p>Нэгтгэж засаж найруулсан.</p> <p>Өөр хэсэгт оруулж найруулсан.</p> <p>Хасагдсан.</p>
7	3.1. Хөдөлгөөнт салбар нь сэргээгдэх эрчим хүчний найдвартай эх үүсвэр, халаалт,	Дараах байдлаар Засаж боловсруулсан.

<p>3. Ерөнхий шаардлага</p>	<p>хөргүүрийн (aircondition) техник хэрэгслүүдээс гадна гэрэлтүүлэг, цахилгааны иж бүрдэл, тусгай дуут дохиоллын систем, банкны карт уншигч машин, шүүгээ, тавиур, электрон жин, электрон кассын машин, зөөврийн компьютер, хэвлэх, хувилах машин, үйлчлүүлэгчдэд зориулсан ширээ, сандал зэргээр тоноглогдсон байна.</p> <p>3.2. Хөдөлгөөнт салбар нь мөн радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хүлээн авагч, фото өнгөт принтер, хиймэл дагуулын төхөөрөмж, байршил-чиглэл тогтоогч /GPS/ зэргээр тоноглогдсон байж болно.</p> <p>3.3. Ажлын байр нь үйлчлэгч, үйлчлүүлэгчдийн тав тухыг хангахуйц багтаамж, зай талбайтай байна. Ажлын байр нь дараах хэсгүүдтэй байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шуудангийн үйлчилгээний хэсэг 2. Интернет үйлчилгээний хэсэг 3. Харилцаа холбооны үйлчилгээний хэсэг 4. Банкны үйлчилгээний хэсэг <p>3.4. Үйлчилгээний ажилтан нь “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажилтанд тавих шаардлага” MNS 5882:2008 стандартын шаардлагыг хангаж ажиллана.</p>	<p>4. “Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын үйлчилгээ Үйлчилгээг дараах байдлаар төрөлжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шуудангийн үйлчилгээ 2.Цахилгаан холбоо, интернэтийн үйлчилгээ 3.Төрийн үйлчилгээ 4.Банкны үйлчилгээ 5 .Бусад үйлчилгээ <p>5. Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын зориулалтын автомашин, ажлын байр</p> <p>5.1 Тавигдах ерөнхий шаардлага</p> <p>5.1.1 Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбарын зориулалтын автомашин нь ус, чийгийн хамгаалалттай, агааржуулагч, халаалттай, 5 тн-оос доошгүй даацтай, гэрэлтүүлэг сайтай, цахилгааны иж бүрэн хамгаалалттай, авар, осол, гаднын халдлагын үед хаалга, нээлхий нь блоклогдож, онцгой байдал, цагдаагийн дуудлагад шууд холбогдох видео камер бүхий дохиолол холбооны систем, үл нэвтрэх салхины шил зэрэг тусгай зориулалтаар тоноглогдсон байна.</p> <p>5.1.2 Ажлын байр нь үйлчлэгч, хэрэглэгчид чөлөөтэй байх норматив хэмжээг хангасан зай талбайтай, үйлчилгээ тус бүрээр дараах хэсгүүдээр төрөлжсөн байна.</p>
<p>8 4. Шуудангийн үйлчилгээний хэсэг 5. Интернет үйлчилгээний хэсэг</p>	<p>4. Шуудангийн үйлчилгээний хэсэг</p> <p>4.1. Шуудангийн илгээмжийг ялган боловсруулах, хадгалах зориулалт бүхий шуудангийн аюулгүй байдал, нууц хадгалалтыг бүрэн хангасан шүүгээ, сейф, электрон жин, кассын машин, үйлчлүүлэгчдэд зориулсан</p>	<p>5.1.2.1 Шуудангийн хэсэг Шуудангийн илгээмж хүлээн авах, гардуулах, марк, дугтуй, ном сонин, сэтгүүл зэргийг борлуулах, хэвлэлийн болон, электрон худалдааны захиалга хүлээн авах зориулалтын техник хэрэгсэл/компьютер, жин, бар код уншигч г,м/-ээр тоноглогдсон лангуутай,</p>

<p>6. Харилцаа холбооны үйлчилгээний хэсэг</p> <p>7. Банк, санхүүгийн үйлчилгээний хэсэг</p>	<p>мэдээллийн самбар зэргээр тоноглогдсон байна.</p> <p>4.2. Үйлчлэгч нь өөрийн шуудангийн имиж өнгө, таних тэмдэг бүхий илгээмжийн сав, баглаа, боодол, хайрцагтай байхаас гадна үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах богц, баадан, шуудангийн хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдсан байна.</p> <p>4.3. Шуудангийн үйлчилгээ нь “Шуудангийн тухай хууль”-ийн 11.1-д заасны дагуу шуудангийн сүлжээгээр дамжин явагдана.</p> <p>4.4. Үйлчлэгч нь хөдөлгөөнт салбараар шуудангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Шуудангийн тухай хууль”-ийн 15.3-т заасны дагуу гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийг ашиглаж болно</p> <p>4.5. Үйлчлэгч нь “Шуудангийн тухай хууль”-ийн 11-14-т заасан үйлчилгээг үзүүлэхээс гадна нэмэлт захиалга, хүргэлтийн үйлчилгээг үзүүлж болно.</p> <p>5. Интернет үйлчилгээний хэсэг</p> <p>5.1. Доргионы хамгаалалттай зөөврийн компьютер 2-оос доошгүй байх ба хэвлэх машин /принтер/, сканераар тоноглогдсон байна.</p> <p>5.2. Интернетэд саадгүй холбогдох /3G, 4G, WiFi, WiMax,/ болон бусад технологиор интернетэд холбогдох боломжтой байна.</p>	<p>шуудангийн хайрцаг, богц болон бусад төрлийн сав баглаа боодолтой байна./Зураг 1 ба 2/</p> <p>5.1.2.2 Цахилгаан холбоо, интернэтийн хэсэг Утасгүй холболт бүхий ширээний эсхүл зөөврийн компьютер, хэвлэгч, хувилагч машин, үүрэн болон суурин холбооны үйлчилгээг үзүүлэх боломжоор хангагдсан байна.. цэнэгч карт борлуулах</p> <p>5.1.2.3 Төрийн үйлчилгээний хэсэг Автомашин болон бусад төрлийн татвар, хураамж, торгуул, иргэний болон бусад төрлийн үйлчилгээ авах зориулалтын цахим киоск байна . / Зураг 3/</p>
--	--	---

		<p>5.3. Интернет, мэдээлэл, электрон худалдаа, сургалтын үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>6. Харилцаа холбооны үйлчилгээний хэсэг</p> <p>6.1. Хувилах машин гар утас болон тэдгээрийг цэнэглэгч тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.</p> <p>6.2. Үүрэн холбооны операторуудын нэгжийн карт борлуулах, гар утсаар яриулах, мессеж, мессеж-факс илгээх, гар утас цэнэглэх зэрэг үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>7. Банк, санхүүгийн үйлчилгээний хэсэг</p> <p>7.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны төлбөрийн карт уншигч машинаар тоноглогдсон байж болно.</p> <p>7.2. Үйлчлэгч нь “Шуудангийн тухай хууль”-ийн 14.2-т заасан санхүүгийн үйлчилгээг эрхэлж болно.</p>	<p>Энэ хэсэг нь төрийн цахим үйлчилгээг таниулах гарын авлага, сургалтын материалуудаар хангагдсан байна.</p> <p>5.1.2.4 Банкны үйлчилгээний хэсэг Банкны үйлчилгээний зориулалтын цахим киоск эсхүл карт уншигчийг суурилуулсан байна./ Зураг 4/</p> <p>5.1.2.5 Бусад үйлчилгээний хэсэг Шаардлагатай тохиолдолд вакцин, тариа хийх, цусны даралт хэмжих зэрэг зорилтот үйлчлүүлэгчид чиглэсэн эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эсхүл ахуй үйлчилгээний зориулалтаар тоноглож үйлчилгээ үзүүлж болно.</p> <p>5.2 Үйлчилгээний талаарх мэдээлэл Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хөдөлгөөнт салбар нь тухайн орон нутагт ажиллах цагийн хуваарь, холбоо барих утас, мэйл хаяг, үйлчлэгчийн лого-г ил тод байршуулсан байна.</p>
9			<p>6. Үйлчилгээний ажилтанд тавигдах шаардлага</p> <p>6.1. Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны мэргэшсэн жолооч, үйлчилгээний ажилтан нь холбогдох хуулийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтэд хүртээмжтэй, үр</p>

			<p>ашигтай үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах, зөв боловсон харьцах, ажлын багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг ашиглах, байгууллагын болон хэрэглэгчдийн нууцыг хадгалах, хамгаалах биеэ хамгаалах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.</p> <p>6.2. “Харилцаа холбооны тухай” хууль, “Шуудангийн тухай” хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам мөн үйлчилгээний технологийг эзэмшсэн, англи болон орос хэлний анхан шатны мэдлэгтэй бичиг үсгийн чадвар сайтай, санхүү, нягтлан бодох, тооцоо бүртгэлийн анхан шатны мэдлэг, дадлагатай, компьютерын болон мэргэжлийн хэрэглээний программ дээр ажиллах, нэг цэгийн үйлчилгээний цахим киоскуудыг ажиллуулах чадвартай ажилтан байна.</p> <p>6.3 Үйлчилгээний ажилтан нь технологийн горимыг мөрдөж хэрэгжүүлэх, ажлын байр болох тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, завсарлан сэргээх, хэрэглэгчдийн тав тухтай орчныг бүрдүүлэх тохижилтын ажлыг хийж байх, нэмэгдэл үйлчилгээ үзүүлэх ажлыг санаачлах, өөрийн үйл ажиллагаанд хяналт дүгнэлт хийх, эрхэлж буй ажлынхаа эцсийн үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх чадвартай байна.</p> <p>6.4 Үйлчлэгч хуулийн этгээд, байгууллага өөрийн ажлын онцлогоос хамаарч үйлчилгээний ээлжийн болон 3 доошгүй нөөц ажилтантай байх.</p> <p>6.5 Үйлчилгээний ажилтан нь үйлчлэгч хуулийн этгээд, байгууллагын лого бүхий дүрэмт хувцастай байна.</p>
--	--	--	---

			<p>7. Үйлчилгээний ажилтны харилцааны ур чадварт тавигдах шаардлага</p> <p>7.1. Үйлчилгээний ажилтан нь хэрэглэгчид угтах, үдэх болон үйлчилгээ үзүүлэх явцад тухайн үйлчилгээ эрхлэгчийн тогтсон харилцааны үг хэллэгийг хэрэглэж хэвшсэн байна.</p> <p>7.2. Үйлчилгээний ажилтан хэрэглэгчтэй эелдэг боловсон харилцан, анхаарал тавьж, үйлчилгээтэй холбоотой дэмжлэг тусалцааг үзүүлж байх.</p> <p>7.3. Ажлын байран дээрх техник технологийг ашиглах, бага хэмжээний доголдол, саатлыг арилгах тохиргоог тухай бүр нь хийх чадвартай байх</p>
10	Гүйцэтгэл	хэвийн	хэвийн
11	Зохиомж	хэвийн	сайжруулсан
12	Стандарт бичиглэл	хэвийн	сайжруулсан
13	Хуудасны тоо/үндсэн болон хавсралт/	4 хуудас	8 хуудас (нүүр хуудас ороогүй)
14	Бусад		Агуулгын хувьд стандартын 75 хувийг шинэчлэн найруулсан.